



НИЙСЛЭЛИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 10 сарын 30 өдөр

Дугаар А/115

Улаанбаатар хот

Худалдан авах ажиллагааг зохион
байгуулах тухай

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.16, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 17 дугаар зүйл, 46 дугаар зүйлийн 46.1.1, 46.1.4, Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2019 оны А/301 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн Онцгой байдлын газрын бүтцийн нэгжүүдэд шаардлагатай бараа, материалыг худалдан авах ажиллагааг зохион байгуулах тендерийн үнэлгээний хорооны бүрэлдэхүүнийг нэгдүгээр, бараа, материалын нэр төрөл, тоо хэмжээ, үнийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Худалдан авах ажиллагааг холбогдох хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулж, төлөвлөгөө боловсруулан батлуулж, хэрэгжилтийг хангуулан дүнг танилцуулахыг үнэлгээний хороо (хошууч Ж.Төмөрмандах)-д үүрэг болгосугай.

3. Тендерийн баримт бичиг бэлтгэх, техникийн тодорхойлолт боловсруулах, тендер зарлах, хүлээн авах, хянан үзэхэд шаардлагатай зардлыг тендерийн баримт бичиг худалдсан орлогоос гаргахыг Санхүү, эдийн засгийн хэлтэс (дэд хурандаа Д.Урантулга)-т зөвшөөрсүгэй.

4. Тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Тэргүүн дэд дарга (дэд хурандаа Н.Нямхорлоо)-д даалгасугай.

ДАРГА,
ХУРАНДАА  Ж.ЧУЛТЭМСҮРЭН



Нийслэлийн Онцгой байдлын газрын даргын
2019 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн
11/15 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



ТЕНДЕРИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

Үнэлгээний хорооны дарга:

Ж.Төмөрмандах

Нийслэлийн Онцгой байдлын газрын Дотоод хяналт, шинжилгээ, үнэлгээ, эрсдэлийн удирдлагын тасгийн дарга, хошууч,

Үнэлгээний хорооны гишүүд:

М. Хаш-Эрдэнэ

Онцгой байдлын ерөнхий газрын УНХТГ-ын ахлах мэргэжилтэн, дэд хурандаа,

Ж. Галбадрах

Онцгой байдлын ерөнхий газрын Санхүү, хөрөнгө оруулалтын газрын барилга байгууламж хариуцсан мэргэжилтэн, дэслэгч,

Б.Сэрдамба

Нийслэлийн онцгой байдлын газрын Санхүү, эдийн засгийн хэлтсийн инженер, ахмад,

Нарийн бичгийн дарга:

А.Нямдорж

Налайх дүүргийн онцгой байдлын хэлтсийн эрсдэлийн мэргэжилтэн

---oOo---

Нийслэлийн Онцгой байдлын газрын даргын
2019 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн
8/115. дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



**ХУДАЛДАН АВАХ БАРАА, МАТЕРИАЛЫН
НЭР ТӨРӨЛ, ТОО ХЭМЖЭЭ, ҮНЭ**

| Д/д | Байгууллагын нэр | Худалдан авах бараа, материал | Тендерийн төрөл | Барааны бүгд үнэ /мян.төг/ |
|----------|------------------------|--|-----------------|----------------------------|
| 1 | Баянзүрх дүүргийн ОБХ | Онцгой байдлын хэлтсийн ГТУАврах 63 дугаар ангийн сантехникийн болон дээврийн засварийн ажил | Харьцуулалт | 42.000.000 |
| 2 | Хан-Уул дүүргийн ОБХ | Онцгой байдлын хэлтсийн ГТУАврах 65 дугаар ангийн гадна бетонон зам талбайн засварын ажил | | 15.000.000 |
| 3 | Налайх дүүргийн ОБХ | Онцгой байдлын хэлтсийн ГТУАврах 28 дугаар ангийн сантехникийн засварийн ажил | | 26.200.000 |
| 4 | Налайх дүүргийн ОБХ | Онцгой байдлын хэлтсийн ГТУАврах 28 дугаар ангийн дээврийн засварийн ажил | | 25.200.000 |
| 5 | Сүхбаатар дүүргийн ОБХ | Онцгой байдлын хэлтсийн ГТУАврах 34 дүгээр ангийн сантехникийн засварийн ажил | | 1.000.000 |
| Нийт дүн | | | | 109.400.000 |